

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
/2006-2015 он/

Оршил

Аймгийн эдийн засаг, нийгмийг алс хэтийн бодлоготой залгамж чанартай хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан аймгийн хөгжлийн стратегийн асуудлуудыг энэхүү хөтөлбөрт тусган боловсрууллаа.

Архангай аймаг 1923 онд байгуулагдсан, Монгол Улсын төв хэсэгт Баянхонгор, Хөвсгөл, Завхан, Булган, Өвөрхангай аймагтай хил залган Хангайн бүсэд оршдог. Өндөр уул, ой, тал хээр хосолсон 55.3 мянган м² нутаг дэвсгэртэй.

Нийт нутаг дэвсгэр нь далайн төвшнөөс 1100-3600 метрт өргөгдсөн, Суварга хайрхан, Баянзүрх, Дулаанхаан,, Ноён хангай, Халзан бүргэдтэйн өндөр уулс, Ар өвөр Жаргалант, Бугат, Бөхөн шар, Булган уул зэрэг үзэсгэлэнт уул нурууд, Галт уулын дэлбэрэлтээс үүсэж тогтсон Хорго, Санжид цохио, Уран мандал, Баян уулын гойд сайхан байгаль, Хөхнуур, Гурван тамирын хөндий, Тоглох, Хонгорж, Бургалдайн өргөн талуудтай билээ.

Хангайн нуруунаас эх авсан хойд, урд Тамир, Тэрх, Суман, Гичгэнэ, Чулуут, Хануй, Хүнүй, Орхон голууд, Тэрхийн цагаан, Өгий, Дөрөө, Айраг зэрэг 240 гаруй нуур цөөрөм, 474 булаг шанд, 546 гол горхи, эмчилгээ сувиллын ач холбогдол бүхий Ноён хангай, Мухар хужирт, Халуун ус, Шивэрт, Хадат, Бор тал, Цагаан сүм, Хануй, Улаан эрэгийн 30 гаруй халуун, хүйтэн рашаантай болно.

Аймгийн нутаг дэвсгэрийн 15.7 хувийг ой мод, 75 хувийг малын бэлчээр, 15 хувийг тариалангийн талбай эзэлж 50 гаруй төрлийн мод бут, эмчилгээнийн зориулалтаар ашигладаг ховор ургамал, самар, жимс жимсгэнэ, шилүүс, бор гөрөөс, буга согоо, гахай, чоно, үнэг, хярс, туулай, чандага, хойлог, хур, хун, сойр, ёл, шонхор, бүргэд зэрэг 390 гаруй төрлийн жигүүртэн шувуу, олон төрлийн загас зэрэг ан амьтан, ургамал ургадаг.

Манай аймагт байгалийн үзэсгэлэнт газраас гадна 2000 жилийн тэртээ хүн амьдарч байсан эртний хүний гал голомтын үлдэгдэл, шинэ чулуун зэвсгийн дараах хүрлийн үеийн өвөрмөц дурсгал, бугын чулуу, Түрэг улсын их хаан Билэгт, түүний дүү хун тайж Культегиний гэрэлт хөшөө, Хар Хорум хотын суурь зэрэг 582 онд босгосон гэрэлт хөшөөнөөс эхлээд 18-19-р зууны үеийн бичигт болон буган хөшөөнүүд, түүхийн эртний хийгээд дундад зууны үеийн эд зүйлс байдаг.

Архангай аймаг 91.1 мянган хүн амтай, 74.9 хувийг хүүхэд залуучууд, 50.3 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Засаг захиргааны 19 сум, 99 багт хуваагдаж аймгийн төв Эрдэнэбулган сум /Цэцэрлэг/-д 17.8 мянган хүн амьдарч байна.

Аймгийн эдийн засгийн үндсэн салбар нь ХАА үүний дотор мал аж ахуй, 2005 оны эцэст 2194.9 мянган толгой мал тоолуулж, мал сүргийн 11.5 хувь нь үхэр, 8.9 хувь нь адуу, 45.2 хувь нь хонь, 34.4 хувь нь ямаа бөгөөд адуун сүргийн тоогоор улсад тэргүүлж, хонь, үхрээр 2-рт орж байна.

Хүнс-Архангай, Илч-Архангай, Авто зам, Шинэ өргөө, Тансаг-Трейд, БЭЭТ, Хасу-Мандал, Гурван тамир зэрэг хүнсний болон худалдааны жижиг үйлдвэрлэл, үйлчилгээний газар, ерөнхий боловсролын 35 сургуульд 21.3 мянган хүүхэд, хувийн хэвшлийн 5 дээд сургууль, багшийн коллеж, МСҮТөвд 1879 оюутан суралцдаг. Сумын болон сумдын эмнэлэг, аймгийн төвд нэгдсэн болон төрөлжсөн, өрхийн хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сангууд ажиллаж, иргэд хөдөлмөрчдөд үйлчилж байна.

2005 оны байдлаар аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 31058.2 сая төгрөгт хүрч нэг хүнд ногдох хэмжээ 339324 төгрөг байгаа нь улсын дундажаас 2.1 дахин бага, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 72 хувийг ХАА-н салбар эзэлж байна.

Иймд аймгийн эдийн засгийн хөгжлийн түвшинг дээшлүүлж, бүтцийг нь шинэчлэх шаардлага тавигдаж байна. Тус аймагт ажилгүйдэл, ядуурал харьцангуй их, ажилгүйдлийн түвшин 4.1 хувь байгаа нь улсын дунджаас 0.6 функтаар өндөр байна.

Хүн амын боловсрол, эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлууд олон байгаагийн дотор боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, хүн амд үзүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүн амын хүнс, тэжээлийн хангамжийг сайжруулах явдал хамгаас чухал байна.

Аймагт урьд өмнө нь ажиллаж байсан үйлдвэрийн газрууд бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй техник, тоног төхөөрөмж, технологи нь хуучирсан, хувьчлалаар хувьд шилжин татан буугдаж үйл ажиллагаа нь зогссон, улсын чанартай томоохон үйлдвэр байхгүй байна.

Манай аймаг нь МАА-н гаралтай түүхий эдийг бэлтгэж боловсруулалт хийх ихээхэн нөөц боломжтой боловч энэхүү нөөцөө бүрэн ашиглаж чадахгүй байна. Иймд МАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг шинээр бий болгох, хүн амын орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Тус аймагт байгалийн баялаг, эрдэс түүхийн эдийн нөөц цөөнгүй байгаа боловч эрэл хайгуул хийж бүрэн судлагдаагүй учир орд газруудыг түшиглэсэн судалгаа, туршилтыг өргөжүүлэх, хөрөнгө оруулагчдад санал болгох, боловсруулах үйлдвэр байгуулах нь аймгийн эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлж, аймаг бие даах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Мянганы замын босоо болон хэвтээ тэнхлэгийн замын сүлжээнд аймгийг холбох түүний дотор сайн чанарын авто замын сүлжээг өргөтгөх явдал тулгамдсан асуудлын нэг болж байна.

Одоогийн байдлаар аймгийн бүх сум төвийн эрчим хүчний системд холбогдсон боловч эрчим хүчний хангамжийг сайжруулах ялангуяа нийт өрхийн 78.1 хувийг эзэлдэг малчин өрхийг эрчим хүчний /нар, салхины/ эх үүсвэртэй болгох шаардлагатай байна.

Цахилгаан холбооны суурь сүлжээг иж бүрнээр нь тоон технологид шилжүүлж, телевизийн олон сувгийг аймгийн нийт сум, багийн нутагт хүлээн авах боломжийг бүрдүүлэх, орчин үеийн мэдээллийн сүлжээнд сумдын төвийг бүрэн холбох хэрэгцээ гарч байна.

Хилийн гарц байхгүй аймгийн хувьд эдийн засгийн дотоод, гадаад хамтын ажиллагааг өргөтгөж эрчимжүүлэх, худалдааны чөлөөт бүс байгуулах шаардлага ч байна.

Сүүлийн хэдэн жилд хүнийн зохисгүй сөрөг үйл ажиллагаа болон байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан ан амьтан, ургамлын төрөл зүйл ховордох, бэлчээр талхлагдах, хөрсний элэгдэл эвдрэл нэмэгдэх цөлжилтийн үйл явц эрчимжих нуур цөөрөм, гол горхи ширгэж усны нөөц багасах, бохирдох зэрэг олон сөрөг нөлөөлөл бий болж байна. Иймээс байгалийн баялагийн нөөцийг судалж, эдийн засгийн үнэлгээ тогтоох, тэдгээрийн экологийн аюулгүй байдлыг хангаж, зохистой ашиглах явдал чухал байна.

Аймгийн ой, ан амьтан, цэнгэг ус, эрдсийн нөөц баялаг, мал аж аухйн түүхий эд, газар тариалан эрхлэх таатай нөхцөл боломж, рашаан сувилал, аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг арвин нөөц, тэдгээрийг ашиглаж ирсэн уламжлал туршлага, үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх явдал цаашдын хөгжлийн гол гарц юм.

Аймаг, сумдад ядуурал, ажилгүйдэл буурахгүй өсөх хандлагатай байгаа, сумдад дэд бүтцийн хөгжил сул, мэдээллийн технологи бүрэн нэвтрээгүй, зах зээлийн багтаамж бага, санхүү төсвийн чадавхи дорой байна.

Архангай аймгийн хувьд газрын хэвлийн баялагийг хамгийн үр ашигтай байгаль орчинд хоргүй, хаягдалгүй орчин үеийн дэвшилтэд техник технологээр ашиглах, МАА, газар тариалан, аялал жуулчлал, амралт сувилал, МАА-н гаралтай түүхий эд боловсруулах жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах явдлыг хөгжлийн ойрын тэргүүлэх гол зорилтууд гэж үзэж байна.

Хөгжлийн энэхүү тэргүүлэх зорилгод хүрэхэд аймгийн дараах давуу талуудыг ашиглана. Үүнд:

- Аймгийн эдийн засгийн хөгжлийг тэргүүлэх чиглэл нь МАА байх.
- Мэргэжил, боловсрол, дадлага туршлагатай боловсон хүчин, хүний нөөц ажиллах хүч
- Бараг онгон төрхөөрөө хадгалагдаж үлдсэн газрын хэвлийн ашигт малтмалын олон төрлийн баялаг нөөц, байгалийн өвөрмөц тогтоц, ховор ан амьтан, ургамлын төрөл зүйл бүхий өргөн уудам газар нутаг
- Төвийн цахилгаан эрчим хүчний системд бүх сум холбогдож, харилцаа холбоо, мэдээллийн дэд бүтэц харьцангуй давуу хөгжсөн.
- Адуун сүргийн тоогоор улсад тэргүүлж, үхрээр II –т ордог
- Мал аж ахуйн гаралтай түүхий эд, сүү цагаан идээ боловсруулах нөөцтэй
- Үр тариа, төмс хүнсний ногоо тариалахад тохиромжтой үржил шимт газар нутаг
- Аялал жуулчлал хөгжих үндэс болсон байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын газартай

Сул тал:

- Эдийн засагт нөлөө үзүүлэх улсын чанартай томоохон үйлдвэр, олзворлох, боловсруулах жижиг дунд үйлдвэр байхгүй.
- Хилийн гарцгүй
- Ажилгүйдэл, ядуурал өсөн нэмэгдэж өрхийн амьжиргааны түвшин доогуур

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдээгүй.
- Бүс нутаг, гадаад эдийн засгийн харилцаа хөгжөөгүй
- Санхүү, төсвийн чадавхи сул

Эдгээр хүчин зүйлийг тооцон үзэж Монгол Улсын Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох Архангай аймгийн хөгжлийн хөтөлбөрийг 2006-2010, 2011-2015 он гэсэн 2 үе шаттайгаар холбогдох судалгаа тооцоо, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн болон Хангай бүсийн хөгжил, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг бүсчилэн хөгжүүлэх чиглэл, аймгийн 21-р зууны хөгжлийн хөтөлбөр, аймгийн Иргэдийн Хурлын төлөөлөгч, сумдын Засаг дарга, эрдэмтэдийн санал бодлогыг нэгтгэж тусгасан болно.

Архангай аймгийн хөгжлийн стратегийн эрхэм зорилго нь:

Газар нутгийн экологийн даацдаа тохируулан байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглан эдийн засгаа тогтворжуулан хөгжүүлж, бие даан хөгжих үндэс суурийг тавьснаар хүн ард нь эрүүл энх, эрдэм боловсролтой, өрхийн амьжиргааны түвшин дээшилж, аюулгүй аятай тохитой орчинд сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх бүс нутаг болох явдал юм.

Нэг. Эдийн засгийн хөгжил

1.1. Аймгийн эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлж тогтворжуулах, салбарын зохистой бүтцийг бий болгох бодлого:

Үндэслэл

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны байдлаар 31058.2 сая төгрөг болж 2000 оныхоос 20.2 хувь, 2004 оноос 4.3 хувь өссөн боловч аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн жил дараалан буурч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 339.3 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 2.1 дахин, хангайн бүсийн аймгуудаас 0.4 дахин бага байна.

Орон нутгийн төсвийн зарлагын 51.8 хувийг өөрийн орлогоороо бүрдүүлж 49.2 хувийг нь улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, дахин хуваарилалтын шилжүүлгийн орлогоор нөхөж байна.

Энэ бүхэн нь манай аймагт татвар төлөх томоохон аж ахуйн нэгж байхгүй, томоохон үйлдвэрүүд хөгжөөгүй байгааг харуулж байна.

Аймгийн эдийн засгийн бүтэц оновчтой биш, сум тус бүрийн хөгжлийн түвшин харилцан адилгүй, уул уурхайн болон малын гаралтай түүхий эд боловсруулах аж үйлдвэргүй, ХАА, ойн баялагийн бүтээгдэхүүн аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 79.3 хувийг эзэлж МАА-н салбар зонхилж, байгаль цаг уурын эрсдэлд өртөгдөх магадлал их, ажилгүйдэл, ядуурал өсөн нэмэгдэж байна.

Иймд аймгийн эдийн засгийг тогтвортой түргэн хурдтай хөгжүүлэх, эдийн засгийн салбарын бүтэцэд өөрчлөлт оруулж боловсронгуй болгох шинээр ажлын байр олноор бий болгох шаардлагатай байна. Үүний тулд сумдыг эдийн засгийн 4 бүс болгон хөгжүүлэх бодлого баримтлана.

Архангай аймгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, тогтворжуулах, ядуурлыг бууруулах хөгжлийн бодлого стратеги:

Тэргүүлэх зорилт	Үе шат/оноор /	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
<p>1. Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 8.0 хувьд хүргэнэ.</p>	<p>2006-2010</p>	<p>-Үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэх стандартын шаардлагад нийцүүлэн эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл харилцаа холбооны зохистой сүлжээ бий болгох.</p> <ul style="list-style-type: none"> - Аймаг, сумын бүсийн давуу тал, нөөцөд тулгуурласан эдийн засгийн шинэ салбар, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох бодлогыг хэрэгжүүлэх. - Сумдын бүсийн төвүүдийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж эхлэх. - Аймаг, сумдын бүсийн төвийн эдийн засгийн чадавхи, дэд бүтцийн багтаамжийг нэмэгдүүлж хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой төвлөрлийг бий болгох. - Аймаг, сумын эдийн засгийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх аж ахуйн нэгжүүдийг өөр хоорондоо хоршин ажиллах, хамтарсан хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгохыг дэмжих. - Үйлдвэрлэл, үйлчилгээний шинэ тодорхой чиглэлээр сумын бүс дотроо дагнах төрөлжих, хоршихыг бодлогоор дэмжиж харилцан нэгнээ нөхөн хангах тогтолцоо бүрдүүлэх. - “Нэг сум-нэг шилдэг бүтээгдэхүүн” хөдөлгөөн өрнүүлж аймаг, сумын бүсийн өрсөлдөх чадвар бүхий брэнд бүтээгдэхүүнийг шинээр бий болгож гадаад, дотоод, бүсийн аймгуудын зах зээлд нийлүүлэх. - “Шилдэг бүтээл, оновчтой санал, шинэ техник технологи, шилмэл бүтээгдэхүүн”-ийг үнэлж, урамшуулах тогтолцоог бий болгох, үзэсгэлэн худалдаа, яармаг гаргаж нийтийн хүртээл болгох. - Аймаг бүсийн сумын эдийн засгийг түлхүү хөгжүүлэх, салбарт оруулах хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх сан байгуулж, төсөв, санхүү, зээлийн бодлогоор дэмжих. - Газар эзэмших, ашиглах, өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар өрхийн амьжиргааны эх сурвалж болгох. - ОХУ, БНХАУ, бусад орон Хангайн бүсийн нутагтай хилийн гарц бий болгож дотоод, гадаад эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлж хөгжүүлэх.

Гарах үр дүн	Аймгийн эдийн засгийн өсөлтийн бүсийн төвүүд бий болж, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээ өргөжин, дотоодын уялдаа холбоо, хамаарал сайжирч, хөрөнгө хүчээ төвлөрүүлснээр бизнес эрхлэх таатай орчин бүрдэнэ.
2. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> - Экспортын баримжаа бүхий боловсруулах аж үйлдвэр /алт, төмрийн хүдэр, зэс гэх мэт/-ийн үйлдвэрлэлийг байгаль орчинд халгүй технологээр үйлдвэрлэх, эрчимжсэн МАА, усалгаатай газар тариалан, аялал жуулчлал, үйлчилгээний салбар хөгжсөн бүс нутгийн эдийн засгийн зохистой бүтцийг бий болгох бодлогыг хэрэгжүүлэх. - Орон нутгийн баялаг нөөцтэй, нөхөн сэргээгдэх түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, ялангуяа мах,махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, арьс шир, ноос, ноолуурын бүтээгдэхүүн, барилгын материал боловсруулах үйлдвэрүүдийг бүсийн төв бүхий суманд эхнийн ээлжинд шинээр байгуулах. - Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, барилгын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг...хувьд хүргэх. - Оёдол, ахуйн үйлчилгээний уламжлалт болон орчин үеийн үйлчилгээнүүдийг шинээр бий болгож өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. - Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжсэн МАА эрхлэхтэй хослуулах замаар ХАА-н хоршилтыг бий болгох, улмаар хөнгөн хүнсний үйлдвэрүүдтэй нягт уялдуулж ХАА- үйлдвэрийн аж ахуйн нэгж байгуулах.
Гарах үр дүн	Бүсийн эдийн засагт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, дэд бүтцийн хангамж, хүртээмж сайжирч үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээ өргөжин тэлнэ.
3. Бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 8.0 хувьд тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.	<p>2006-2015</p> <ul style="list-style-type: none"> -Бүсийн үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад зах зээлд өрсөлдөх чадвартай оюуны өндөр багтаамжтай менежментийг нэврүүлэх орчин үеийн дэвшилтэд техник, технологи дээр тулгуурласан боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх. - Экспортын баримжаатай хувийн хэвшилд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэх замаар эдийн засгийн өндөр өсөлтийг хангах. - Эрдэс, түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглахад чиглэсэн үйлдвэрлэлийг өргөтгөх.

		<p>-Сумдын хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх.</p> <p>- Аймгийн эдийн засгийн бүсийн хөгжлийн төвүүдийн хоорондын зохистой харьцаа, хоршилтыг тогтоож, тэдгээрийг холбон хөгжүүлэх дэд бүтцийн үндсэн сүлжээг бүрдүүлэх.</p> <p>- Нутгийн өөрөө удирдах байгууллагын эдийн засгийн зохицуулалтын эрх мэдлийг өргөтгөх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.</p> <p>- Орон нутгийн өмч, татвар, санхүү, зээлийн эрх хэмжээг өргөтгөх.</p>
	Гарах үр дүн	Өөрийгөө тэтгэдэг, өрсөлдөх чадвар бүхий, хөрөнгө хүчээ нэгтгэсэн бүсийн эдийн засгийн үндсийг бий болгож, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэнэ.
4. Аж үйлдвэр үйлчилгээний салбарын бүтээгдэхүүний хэмжээг тогтвортой нэмэгдүүлж, эдийн засгийн салбарын бүтцийг улам боловсронгуй болгоно.		<p>- Сумдыг бүсчилэн хөгжүүлж, бичил бүсүүдийг эдийн засгийн талаар төрөлжүүлэн хөгжүүлэх.</p> <p>- Сумдын бүсийн төвүүдэд үйлдвэрлэл, технологийн холимог, дагнасан хэлбэрийн паркийг байгуулах.</p> <p>- Хоргын бүсэд уул уурхай /алт, үнэт чулуу/ барилгын материал, сарлагын хөөвөр, хялгас, аялал жуулчлал, Хүнүйн бүсэд арьс шир, түүхий эд боловсруулах, рашаан амралт, Өгийн бүсэд уул уурхай, газар тариалан, хөнгөн хүнсний үйлдвэр, аялал жуулчлал, усалгаатай газар тариалан, Булган уулын бүсэд хөнгөн аж үйлдвэр, аялал жуулчлал, рашаан амралт, газар тариаланг түлхүү хөгжүүлэх.</p> <p>- ХАА-н экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх.</p>
	Гарах үр дүн	Байгаль орчин, түүний нөөц, ХАА-д зохицсон өөрийгөө тэтгэх боломжтой эдийн засгийн зохистой бүтэц бүрдэнэ.

1.2. Аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын хөгжил:

1.2.1. Хөдөө аж ахуйн хөгжил:

Үндэслэл

Аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбар нь хөдөө аж ахуй үүний дотор мал аж ахуй зонхилсон хэвээрээ байна. 2005 оны байдлаар аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд ХАА-н салбарт бий болгосон нэмэгдэл өртөг нь 22.3 .сая төгрөг буюу 72.2 хувь байна.

Бэлчээр талхлагдах, гол горхи ширгэх, гал түймэр, зүй бус ашиглалтаас болж ой, ан амьтан, ургамлын нөөц хомсдох, төв суурин, зам бараадан хүн, мал бөөгнөрөх сөрөг хандлагууд гарч байна.

Цаашид ХАА-н салбарыг сэргээж хөгжүүлэх, эрчимжүүлэх, МАА-г хагас суурин хэлбэрт шилжүүлэх, малын таваарлаг чанар, үүлдэр угсааг сайжруулах эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх, усалгаатай газар тариалангийн технологид шилжих, газар тариалангийн бүтээгдэхүүнээр аймгийн хэрэгцээг хангадаг болох, өрх бүрээр туслах аж ахуй эрхлүүлэх зэрэг тулгамдсан зорилтууд цөөнгүй байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Аймгийн ХАА-н үйлдвэрлэлийн одоогийн бүтэц, зохион байгуулалтыг зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгож, менежментийг сайжруулна.	2006-2010	<ul style="list-style-type: none"> - Малчид, тариаланчдын бүлэг, фермер, хоршоо байгуулах хамтын ажиллагааны хэлбэрүүдийг дэмжиж, МАА, газар тариалан, туслах аж ахуйг хослон хөгжүүлэх эрчимжсэн технологи бүхий хоршоо, фермерийн болон гахай, тахиа, зөгийн аж ахуйг байгуулж, хөгжүүлэхийг урамшуулан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх. - Таримал ургамал, үр бордоо, өндөр ашиг шимт болон нутгийн шилмэл омгийн хээлтүүлэгч, өсвөр гахай, өндөглөгч бойжуулан аж ахуйн нэгж, айл өрхийг хангах санал, санаачлагыг дэмжих. - Сум бүрт загвар хоршоо, фермер байгуулж, ахмад үеийн ажлын арга барилыг залуу малчдад зааж сургах, үзүүлэх сургууль зохиох, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийн сургалтанд хоршоо, бүлгийн малчид, мэргэжилтнүүдийг хамруулах. - ХАА-н үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах, мал сүргийг индексжүүлсэн даатгалд хамруулах.
Гарах үр дүн		ХАА-г сэргээн хөгжүүлж, хүн ам, үйлдвэрийн ХАА-н түүхий эд бүтээгдэхүүний дутагдаж байгаа хэрэгцээг үндсэнд нь хангах нөхцөл бүрдэнэ.
2. ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжсэн хэлбэрээр хөтлөх үндсийг тавина.	2011-2015	<ul style="list-style-type: none"> - Аймаг, сумдын бүсийн төвийн орчимд эрчимжсэн бүтэц, технологиор ХАА-г эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх. - Экологийн цэвэр ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалтыг нэмэгдүүлэх. - Бэлчээрийг усжуулах ажлыг нэмэгдүүлэх. - ХАА-н гаралтай түүхий эдийг бэлтгэх, борлуулах биржүүдийг аймаг, бүсийн төв бүхий сумдад байгуулах.
Гарах үр дүн		ХАА-н түүхий эдийн бүтээгдэхүүний хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр бүрэн хангаж, Хангайн бүс, УБ-ын зах зээлд борлуулдаг болно.

1.2.1.1 Мал аж ахуй:

Үндэслэл

2005 оны байдлаар аймгийн нийт мал сүрэгт тэмээ...хувь, адуу 8.9 хувь, үхэр 11.5 хувь, хонь 45.2 хувь, ямаа 34.4 хувийг тус тус эзэлж, 18947 малтай өрх байгаа бөгөөд амины малтай нэг өрхөд 115 мал ногдож байна.

Нийт сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийн жин хонинд 43.3, ямаанд 0.3, үхэрт 1.1, адуунд 0 болж өмнөх жилүүдээс дахин буурчээ.

Сүүлийн жилүүдэд малын үүлдэр, удам угсааг сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх ажил зах зээлийн шаардлагаас хоцорч, фермерийн аж ахуй эрхлэх ажил эхлээгүй, мал сүргийн усан хангамж, малын тэжээлийн болон бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангалтгүй байна.

Зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч сүргийн бүтэцэд ч зарим сөрөг өөрчлөлт гарч, бэлчээр ашиглалтад зарим талаар сөргөөр нөлөөлж, малын ашиг шим /ноос, хөөвөр, хялгас гэх мэт/-ийг бүрэн ашиглах, цагаан идээг амт чанар, өнгө үзэмжтэй хийх уламжлалт арга мартагдахад хүрч, мал аж ахуйн үйлдвэрлэлд техник технологийн шинэчлэл бүрэн нэвтрээгүй малын ашиг шимийг бүрэн ашиглаж чадахгүй үхэр, тэмээн сүрэг хорогдож байна.

Иймд малын тоо толгойг зохистой хэмжээнд барьж, сүргийн бүтэц, чанарыг сайжруулах замаар ашиг шимийг нь нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Жилд дунджаар 1000тн ноос, 120тн ноолуур, бодын хөөвөр 45тн, хялгас 100тн, 213000ш үхэр, хонины арьс шир, 17.0 мянган литр сүү, 650тн цөцгийн тос, 6800тн мах бэлтгэх нөөц боломж байна.

Иймээс МАА-г хөгжүүлэх, малын гаралтай түүхий эдийг дахин боловсруулах, экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэхэд түүхий эдийнхээ дээрх нөөцийг нэмэгдүүлэх, ашиг шимийг нь сайжруулах чиглэлээр МАА-г хөгжүүлэх, түүхий эдээ бүрэн бэлтгэх, боловсруулалт хийж бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал нэн тулгамдсан зорилт болж байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Бэлчээрийн МАА-г зах зээлийн эрэлт, хэрэгцээ, бүс нутгийн онцлогт тохируулан үр ашигтай эрхлэн хөтлөх арга хэлбэрт шилжүүлж, бүсийн төв суурин газарт МАА эрхлэх ажлыг өргөжүүлнэ.	2006-2010	- Бэлчээрийн даац, усан хангамжийг харгалзан мал сүргийг зохистой тоо, бүтэцтэйгээр өсгөн үржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх. - Суманд эрчимжсэн МАА хөгжүүлэх эхлэлийг тавих. - Үхэр сүргийн тогтвортой өсөлтийг хангах аймгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. - Манлай малчдын зөвлөлгөөн сургалт зохион байгуулах. - Нутгийн шилмэл омгийн удмын сан бүрдүүлэх. - Өндөр ашиг шим бүхий мах, сүүний чиглэлийн үхэр /Сэлэнгэ, Алатау/ нутгийн сарлаг, Байдраг, Илүү нугаламт хонь, Өлгийн улаан ямааг сайжруулагчаар ашиглан, тоо толгойг нь нэмэгдүүлэх, Үржил селекцийн ажил явуулж, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах. - Малын сүүгээр олон төрлийн бүтээгдэхүүн хийдэг уламжлалт аргыг дэлгэрүүлж, энэ чиглэлийн боловсруулах жижиг үйлдвэр

		<p>байгуулж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд гаргах.</p> <ul style="list-style-type: none"> – Сарлагын хөөвөр, хялгас боловсруулах үйлдвэрийг Тариат суманд байгуулах, Ихтамир сумын эсгий, эсгийн гутлын үйлдвэрийн хүчин чадлыг нь бүрэн ашиглах. – Малын хулгай, чонотой тэмцэх хөтөлбөр гарган хэрэгжүүлэх. – Мал эмнэлгийн үйлчилгээг зах зээлийн зарчимд нийцүүлэн мал эмчлэх, үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх. – Мал эмнэлгийн ариун цэвэр, магадлан шинжилгээний лабораторийн техник тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ, оношлогооны чадавхийг дээшлүүлэх. - Мал сүргийн усан хангамжийг нэмэгдүүлэх, тэжээлийн үйлдвэр байгуулах.
	Гарах үр дүн	<p>МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ 2005 онтой харьцуулахад жилд дунджаар 4.4 хувь өснө. Нийт сүргийн дотор ашиг шим ихтэй малын эзлэх хувийн жин 30.0 хувьд хүрч, малын өвчнөөр хорогдох тоо хэмжээ 2005 оныхоос 10.0 хувь буурна.</p>
2. ХАА-г хагас суурин хэлбэрт шилжүүлж, эрчимсэн аж ахуй болгон экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн мал сүргийг эрүүлжүүлнэ.	2011-2015	<ul style="list-style-type: none"> - Мах, сүүнийн эрчимжсэн аж ахуйг өргөжүүлж, сумын бүсийн төвүүдийг түшиглэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх. – Цөм сүрэг бүрдүүлж, хээлтүүлэгч бойжуулах ажлыг хуцаар Хотонт, Цахир сумдад, бухаар Тариат суманд зонхилон явуулах. – Мах, ноос, ноолуур, арьс ширийг стандартын дагуу бэлтгэх, боловсруулах жижиг, дунд үйлдвэр байгуулж, ашиг шимийг нь бүрэн ашиглах дотоод, гадаадын зах зээлд борлуулах. – Сэлэнгэ үүлдрийн үхэр сүргийн үржлийн аж ахуй байгуулах. - Өндөр ашиг шимт малын хээлтүүлэгч, түүний үр хөврөлийг үржилд өргөн ашиглах. – Ноолуурын ямааны шилмэл омгийн цөм сүрэг бүрдүүлж, өсгөн үржүүлэх. – Мал эмнэлгийн техник, технологи, эм хангамжийг сайжруулж, малын халдварт паразитийн өвчнөөс урьдчилан сэргийлэх. – Ихтамир сумын МАА-н эрдэм шинжилгээний салбарыг өргөжүүлж хөгжүүлэх. – Малын тэжээлийн үйлдвэр байгуулж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.
	Гарах үр дүн	<p>Мал сүргийн дотор өндөр ашиг шимтэй малын эзлэх хувийн жин 40.0 хувьд хүрч, МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл жилд дунджаар 6.0 хувь өснө.</p>

1.2.1.2. Газар тариалан:

Үндэслэл

Архангай аймаг 49.5 мянган га эргэлтийн талбайд газар тариалангийн үйлдвэрлэл явуулж, 1995 онд үр тариа 10582тн, төмс, хүнсний ногоо 1558тн-ыг хураан авч өөрийн аймгийн хэрэгцээг хангахын зэрэгцээ ХарХорины гурилын үйлдвэрийн жилийн хэрэгцээт будааны 60 хувийг нийлүүлж байсан. Нэгдэл, САА-н бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөн хувьчлагдснаар газар тариалангийн үйлдвэрлэл зогсч, 2005 онд 720тн үр тариа, 1344.7тн төмс, хүнсний ногоо хураан авч үр тарианы үйлдвэрлэл 2003 оноос 3.8 дахин буурчээ.

Байгаль цаг уур өөрчлөгдөн хөрсний үржил шим муудсан, тариалангийн талбай, га-аас авч байгаа ургацын хэмжээ бага, техник технологи хуучирч, үнэ ихтэйгээс газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхэд хөрөнгө санхүүгийн чадавхийн ихээхэн бэрхшээлтэй болж аймгийн хүн амын гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээ гаднаас хангагдаж байна.

Эдгээр нь хүний эрүүл ахуйн шаардлагыг зохих ёсоор хангахгүй, чанар стандарт ч хангалтгүй байна.

Иймд газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх үндсэн дээр хүнсний эрүүл ахуйн шаардлага стандарт хангасан үр тариа, төмс, хүнсний ногоогоор дотоод хэрэгцээг хангах, хүлэмжийн аж ахуй байгуулах, нарийн ногоо тариалах иргэд, аж ахуй нэгжийн санаачлагыг дэмжин дэлгэрүүлэх шаардлагатай байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээж хөгжүүлэх, усалгаатай тариалангийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.	2006-2010	- Үр тариа, төмс, хүнсний ногоо, хүнс тэжээлийн үет, буурцагт ургамал, жимс жимсгэнийг тариалж дотоодын хэрэгцээг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх. – Энгийн болон инженерийн хийцтэй услалтын системийг сэргээх, гол, усны эх булаг, цасыг хамгаалж хашаалан усалгаатай тариалан эрхэлж, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал, хадлангийн ургацыг нэмэгдүүлэх. – Орон нутгийн нөхцөлд тарьж болох жимс жимсгэний аж ахуй байгуулах. – Төвшрүүлэх суманд усалгаатай тариалан хөгжүүлж, малын тэжээлийн үйлдвэр байгуулах. – Газар тариалангийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр үйлчлэх, сэргээн засварлах, үр бордоогоор хангах лизингийн үйлчилгээ, бага механикжуулалтыг нэвтрүүлэх. – Газар тариаланд хөрсний эвдрэлээс хамгаалах технологи нэвтрүүлж, хөнөөлт шавьж, хортон, өвчин, хог ургамалтай тэмцэх зориулалтай бодисын олдоц

		<p>хангалтыг сайжруулах.</p> <ul style="list-style-type: none"> – Услалтын системийн барилга байгууламжийг шинээр барьж байгуулах, засварлахад чиглэсэн санаачлага, хөрөнгө оруулалтыг дэмжиж, гадаад, дотоодын зээл, тусламжийн хөрөнгийн зарим хэсгийг түүнд чиглүүлэх. - Үрийг нөөцлөж хадгалах, төмс, хүнсний ногооны агуулах зоорийн хүчин чадал хангамжийг нэмэгдүүлэх санаачлагыг дэмжих. – Айл өрхөд газар тариалан, жимс жимсгэний тарьц, суулгац үржүүлэх, туслах аж ахуйг хөгжүүлэх ажлыг бүх нийтийн хэрэгцээ болгох хөдөлгөөн өрнүүлж, тарвас ургуулах, хамгаалах хадгалах, боловсруулж хүнсэнд хэрэглэх мэдлэг түгээх, мэдлэг олгох /экстейншины/ үйлчилгээг өргөжүүлэх. Хөрсний эвдэрэл, үржил шимийг нь нөхөн сэргээх. – Иргэд, тариалан эрхлэгчдэд газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх.
Гарах үр дүн		Хүн амын гурилын хэрэгцээний 10.0 хувь, төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр хангах нөхцөл бүрдэнэ.
2. Усалгаатай газар тариалангийн хэмжээ, 1га-аас авах ургацыг нэмэгдүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.	2011-2015	<ul style="list-style-type: none"> - Төмс, хүнсний ногооны талбайн чийгийн ууршилтыг бууруулах, хог ургамлын ургалтыг хязгаарлах, дулаан хуримтлуулан байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалан даатгалд хамруулах, ургац нэмэгдүүлэх арга технологийг эзэмшүүлэх, дэлгэрүүлэх. – Халуун рашаан, дулааны найдвартай эх үүсвэртэй газруудад жилийн турш ажиллах хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх. – Ганд тэсвэртэй, богино хугацааны болцтой, 1га-аас авах ургацын хэмжээ их үрийн сантай болох. – Хүнс, техник, тэжээлийн таримлын нэр төрлийг олшруулах, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хүлэмж байгуулж нарийн ногоо ургуулах ажлыг дэмжин хөгжүүлэх.
Гарах үр дүн		Газар тариалангийн бүтээгдэхүүнээр хүн амын хүнсний хэрэгцээг дотооддоо бүрэн хангана.

1.2.2. Аж үйлдвэрийн хөгжил:

Үндэслэл

Тус аймагт аж үйлдвэрийн салбар хөгжөөгүй, 2005 оны байдлаар аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд энэ салбарын эзлэх хувийн жин...хувьтай, жижиг хүнсний чиглэлийн үйлдвэр хөгжиж, алт олборлох үйлдвэрлэлд гадны аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна.

Төвшрүүлэх, Хайрхан суманд гурилын, Тариат, Эрдэнэбулган суманд барилгын материал, ахуйн үйлчилгээний үйлдвэрүүд ажиллаж байгаад үйл ажиллагаа нь зогссон.

Аймгийн нутаг дэвсгэрт хийгдсэн хайгуулын судалгаагаар 60 гаруй ашигт малтмал, эрдэс баялагийн орд, нүүрс, алтны 3 илэрч тогтоогдсон хэдий ч ашиглах, олзворлох шатанд хүртэл хийгдсэн нарийвчилсан хайгуул судалгаа хийгдээгүй байна.

Иймд байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, цэвэр, бохир усны байгууламжтай, аймгийн төв, бүх сум төвийн эрчим хүчний системд холбогдсон давуу талуудыг ашиглаж эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлж орлогын эх үүсвэр бий болгоход онцгой анхаарах шаардлага тавигдаж байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Байгаль орчинд зохицсон, эдийн засгийн бусад салбаруудын хөгжилтэй уялдан нийцсэн нөөц боломжоо ашиглан тэргүүний техник, технологид тулгуурласан хүн ам, үйлдвэрлэлийн эрэлт хэрэгцээ шаардлага хангах аж үйлдвэр, барилгын материалын үйлдвэр хөгжүүлж, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувийн жинг 5.0 хувьд хүргэнэ.	2006-2010	- Барилгын материалын үйлдвэрлэлийг сэргээн, хямд зардалтай техник, технологийн шинэчлэлт хийх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. – Байгалийн баялагийг ашиглах, уул уурхайн түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх. – Хөнгөн, хүнсний үйлдвэрийн чиглэл, жижиг, дунд үйлдвэрүүдийн байршил, бүтцийг оновчтой тогтоож хөгжүүлэх. - Өгийнуур суманд хүдэр боловсруулах үйлдвэр, даацын хүрмэн блок үйлдвэрлэх цехийг Тариатад байгуулах.
Гарах үр дүн		Аймгийн эдийн засгийн салбарт аж үйлдвэрийн эзлэх хувийн жин нэмэгдэнэ.
2. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувийн жинг 10.0 хувьд хүргэнэ.	2011-2015	- Аж үйлдвэр, уул уурхайн түүхий эд, эрдэс баялагийг иж бүрдэл боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогыг хэрэгжүүлэх. – Модны нөөцийг түшиглэн...суманд мод боловсруулах үйлдвэр байгуулах, модны тарьц үржүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага,

		иргэдийг дэмжих. – НАА, ахуйн үйлчилгээний орчин үеийн төрөл бүрийн жижиг үйлдвэрүүд байгуулахыг бодлогоор дэмжиж ажиллах. – Оёдол, нэхмэл, сүлжмэл эдлэлийн болон мах, хүнсний ногоо нөөшлөх, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг дэмжин өргөтгөж хөгжүүлж ард, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чанартай бүтээгдэхүүнээр хангах.
		- Цэцгийн тос, сүү цагаан идээ боловсруулах орчин үеийн технологи бүхий үйлдвэрийг суманд байгуулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх. – Хог хаягдлыг ялгах дахин боловсруулах цехийг Эрдэнэбулган суманд байгуулах. – Алт, нүүрсний орд, илэрлүүдийн нарийвчилсан судалгаа хайгуул хийж, олборлолт явуулах асуудлыг шийдэх. – Ихтамир сумын Мөнгөтийн мөнгөний ордод хайгуул хийж, ашиглалт явуулах техник, технологийн үндэслэлийг боловсруулах. – Тариат сумын шаврын царамын гоёлын өнгөт чулууны ордыг ашиглаж гоёл чимэглэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
Гарах үр дүн		Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, бүтээгдэхүүний нэр төрөл олширон, боловсруулах олборлох аж үйлдвэртэй болно.

1.2.3. Аялал, жуулчлалын хөгжил:

Үндэслэл

Манай аймаг нь түүх, соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууддаа түшиглэн дотоод, гадаадын аялал, жуулчлалыг хөгжүүлэх тохиромжтой, одоо тус аймагт аялал, жуулчлалын 17 бааз үйл ажиллагаа явуулж 2005 онд 12383 зочин, төлөөлөгчдийг хүлээн авч үйлчилж байна.

Гэвч эдгээр баазуудын үйлчилгээ улирлын чанартай, материаллаг бааз, үйлчилгээний чанар ОУ-ын стандартын шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна. Иймээс байгаа материаллаг бааз дээрээ түшиглэн тэдгээрийг өргөтгөх, шинээр байгуулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар бүсийн аймгуудыг хамарсан аялал, жуулчлалын сүлжээ байгуулах, аялал, жуулчлалын үйлчилгээний чанарыг ОУС-ын түвшинд хүргэх нь тулгамдсан асуудал болж байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Аялал жуулчлалын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг дэмжин нэмэгдүүлж, менежментийг сайжруулах замаар аялал жуулчлалын сүлжээ байгуулж, стандартын шаардлагыг хангуулна.	2006-2010	<p>-Аялал, жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт хийхийг дэмжих.</p> <p>- Аялал, жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө /хөтөлбөр/ боловсруулан хэрэгжүүлэх.</p> <p>– Хашаат сумын хөшөө цайдамд жуулчид хүлээн авах байр барих, Цэнхэр, Хотонт, Ихтамир, Тариат, Өгийнуур зэрэг сумын баазуудыг жуулчдад үйлчлэх түвшинд хүргэж тохижуулан өргөтгөл, үйлчилгээний чанар, стандартын шаардлагыг хангуулах, ажлыг үе шаттай хийх.</p> <p>– Архангайн Өгийнуур, Хашаат /Хөшөө цайдам/ Хар-Хорин, Эрдэнэзуу, Тариат Хорго, УБ-ын чиглэлээр аялал жуулчлалын бүс маршрут гаргах.</p> <p>- Аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбогдуулан авто зам, цахилгаан дамжуулах шугам, мэдээлэл холбооны сүлжээ бий болгох, зочид буудлуудын тоог нэмэгдүүлэх, зэрэглэлийг нь дээшлүүлэх.</p> <p>– Жуулчлалын мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх.</p>
Гарах үр дүн		Гадаад, дотоодын зочин төлөөлөгчдийн аялал жуулчлалд хамрагдах тоо нэмэгдэж бүтээгдэхүүний хэмжээ өсч, үйлчилгээний чанар сайжирна.
2. Эдийн засагт аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар, менежментийг нь ОУС-ын түвшинд хүргэж сайжруулна.	2011-2015	<p>- Хангайн бүсийн аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбогдох.</p> <p>– Улаанбаатар-Хар Хорин- Цэцэрлэг- Тариат гэсэн аялал жуулчлалын үйл ажиллагааг жигдрүүлэх.</p> <p>– Аялал, жуулчлалын нэр төрлийг олшруулах, байгалийн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх.</p> <p>– Жуулчдыг 4 улиралд хүлээн авах боломжтой ОУ-ын жишиг стандартад нийцсэн бааз байгуулах.</p> <p>– Халуун, хүйтэн рашааныг түшиглэн эмчилгээ сувиллын төвүүд байгуулах, үйлчилгээний чанар стандартыг хангуулах.</p>
Гарах үр дүн		Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жинг 10.0 хувьд хүргэнэ.

1.2.4. Дэд бүтцийн хөгжил:

Үндэслэл

Аймаг, сумын төв эрчим хүчний системд холбогдож, улс, орон нутгийн зам, мэдээлэл харилцаа холбоо зохих түвшинд хөгжиж байгаа боловч эрчим хүчний найдвартай эх үүсвэр бий болгох, ялангуяа сум, багийн төв, хөдөөгийн малчин өрхүүдийг сэргээгдэх эрчим хүчээр хангах, дэд бүтцийн салбарт шинэ хэмнэлттэй техник, технологийг нэвтрүүлэх, Цэцэрлэг хотын хатуу хучилттай зам хөгжлийн шаардлагаас ихээхэн хоцрогдож байна.

Аймгийн чиглэл дэх Мянганы замын хатуу хучилттай замыг барьж дуусгах, Ханх- Хатгал- Мөрөн- Цэцэрлэгийн замыг сайжруулж мянганы хэвтээ тэнхлэгтэй холбох, босоо тэнхлэгийг барих ажлыг эхлүүлэх эрчим хүч, дулааны үнийг хямдруулах, халаалтын шинэ технологийг нэвтрүүлэх, шуудан тээврийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

Аймаг, сумдын төвийг холбооны тоон технологид бүрэн шилжүүлж холбох нь цаашдын тулгамдсан асуудал болж байна.

1.2.4.1 Зам, тээврийн хөгжил:

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Бүсийн авто замын сүлжээ, тээврийн цаашдын хөгжлийн үндсийг тавина.	2006-2010	- Мянганы зам барих ажлыг үргэлжүүлэх, түүний дагуух гүүр барих, даваа засах ажлыг зохион байгуулж, эрчимжүүлэх. – Дашинчилэн-Өгийнуур-Батцэнгэлийн Хануйн гүүр барих, Хар Хорин- Цэцэрлэг-Тосонцэнгэлийн босоо чиглэлийн авто замыг хайрган хучилттай болгох. – Цэцэрлэг хот доторхи хатуу хучилттай замыг засварлах, орон нутгийн гүүр, даваануудыг засч сайжруулах, шинээр барих. – Шуудан, тээврийн үйлчилгээг нийгмийн хөгжлийг хангах чиглэлд нийцүүлэн хөгжүүлэх, тээврийн мэдээлэл дамжуулах сүлжээ байгуулах.
Гарах үр дүн		Бүс нутгийн тээврийн сүлжээ бий болж “Мянганы зам” барих ажил эрчимжиж зорчигч болон ачаа тээвэрлэлтийн нөхцөл сайжирна.
2. Цэцэрлэг хотын зам талбай, гэрэлтүүлэг, ногоон бүс, орон нутгийн зам, гүүрийг ээлж дараатай засварлана.	2011-2015	-Ерөнхий төлөвлөгөөний дагуу зам, гүүрийг засч сайжруулан, гэрэлтүүлэг, ногоон бүс бий болгох. – Аймгийн төв-гэр хороололд хатуу хучилттай зам тавих. – Замын сангийн хөрөнгөөр орон нутгийн чанартай зам, гүүрийг засч сайжруулах. – Хар Хорин-Цэцэрлэгийн 135км-ийн замыг хатуу хучилттай болгох.
Гарах үр дүн		Зам тээврийн сүлжээ сайжирч аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд таатай нөлөө үзүүлнэ.

1.2.4.2 Эрчим хүчний салбарын хөгжил:

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Эрчим хүчний системийг зохистой өргөтгөж, эрчим хүчний хямд, найдвартай эх үүсвэрүүдийг шинээр бий болгож амьдрах нөхцөлийг сайжруулна.	2006-2010	<ul style="list-style-type: none"> - Чулуут сумын чулуун нүүрсний орд газрын нарийвчилсан хайгуул судалгааг хийлгэх. – Сумдад сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр барих. – Буман нарны гэр, 100000 нарны гэрэл” хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хөдөөгийн малчин өрхийг нарны эх үүсгүүрээр хангах. – Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхөд урьдчилсан төлбөрт болон 3 тарифт тоолуурыг нэвтрүүлж хэрэглэгчдийг урамшуулан, гэрэл цахилгааны үнийн дарамтыг бууруулах. – Түлш дулаан эрчим хүчний алдагдлыг багасгаж, дулаан хэмнэлттэй техник технологи нэвтрүүлэх.
Гарах үр дүн		Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж байгууллага, иргэдийн амьдрах нөхцөл сайжирна.
2. Байгаль орчинд хоргүй, үр ашигтай эрчим хүч, дулааны техник, технологи нэвтрүүлж, үйлдвэр үйлчилгээний үр ашгийг дээшлүүлнэ.	2011-2015	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг үргэлжүүлэн зохион байгуулах. – Нар, салхины сэргээгдэх эрчим хүч, бусад дэвшилтэд технологи нэвтрүүлэх замаар сумын төв, баг, малчин өрхийг цахилгааны байнгын эх үүсвэртэй болгох.
Гарах үр дүн		Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хэрэглээ нэмэгдэж сум, баг бүх малчин өрхүүд сэргээгдэх эрчим хүчээр хангагдана.

1.2.4.3. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжил:

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Мэдээлэл холбооны орчин үеийн үйлчилгээ, хэрэглээг эрчимтэй нэвтрүүлнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> - Сумдын бүсийн төвүүдийг орчин үеийн АТС-тэй болгож мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах. - Зарим сумдад хөдөлгөөнт холбооны систем тавих. - Дашинчилэн- Архангайг өндөр хурдын шилэн кабелиар холбох. - Аймгийн телевизийн дахин дамжуулах станцыг шинэчилж бүх айл өрхөд кабелийн телевиз үзүүлэх. - Сумдын төвийг олон сувгийн нэвтрүүлэх үзэх боломжтой болгох. - Интернэтийн үйлчилгээг сумдад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.
Гарах үр дүн		Холбооны үйлчилгээнд тоон систем бүрэн нэвтрэнэ.
2. Мэдээлэл холбооны хэрэглээ үйлчилгээг бүх нэгжид нэвтрүүлнэ.	2011-2015	<ul style="list-style-type: none"> - Аймаг, сумын хооронд дамжуулах системийг тоон сүлжээнд бүрэн шилжүүлэх. - Суурин телефоны цэгийн нягтрлыг нэмэгдүүлэх. - Интернэтийн үйлчилгээг сумдад нэвтрүүлэх. - Үүрэн телефон хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлж, малчдыг холбоожуулах боломжийг бүрдүүлэх.
Гарах үр дүн		Мэдээлэл, холбооны техник, технологи байгууллага, хүн амын ахуйн хэрэглээнд бүрэн нэвтрэнэ.

Хоёр. Нийгмийн хөгжил

2.1. Хүн амын өсөлт, хүний хөгжлийг хангах талаар:

Үндэслэл

Аймгийн нийт хүн ам 91092 болж 1995 оноос 5108 хүнээр, 2001 оноос 6142 хүнээр тус тус буурч, 50.3 хувь нь эмэгтэй, 49.7 хувь нь эрэгтэй, 35572 буюу 39.1 хувь нь аймаг, сумын төвд 55520 буюу 60.9 хувь нь хөдөөд тус тус оршин амьдарч байна.

1000 хүнд ногдох хүн амын төрөлтийг 2000 оныхтой харьцуулбал 2005 онд 39.4 хувь, 1000 хүнд ногдох хүн амын цэвэр өсөлт 2000 онтой харьцуулбал 2005 онд 45.5 хувь тус тус буурсан байна.

1-5 насны хүүхдийн нас баралт 2004 оныхоос 2005 онд 64.3 хувь буурсан боловч нялхсын эндэгдэл 21.4 хувь өссөн байна. Аймгийн нийт хүн амын 37.9 хувийг 0-16 насны хүүхэд, 37.0 хувийг хөдөлмөрийн насны залуучууд, 5.9 хувийг 65-аас дээш насныхан тус тус эзэлж байна.

2005 оны байдлаар аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 74.8, ажил эрхлэлтийн түвшин 71.7 болж хөдөлмөр эрхлээгүй 6451 хүн байгаагаас хөдөлмөрийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж буй ажилгүйчүүд 1638 болж 2004 оныхоос 7.7 хувь өсчээ.

Аймагт төрөх насны 15-49 эмэгтэйчүүд 25749, 2005 онд 1540 эх төрж 1454 хүүхэд мэндэлсэн нь төрсөн хүүхэд 2004 оныхоос 6 хувь буюу 92-оор буурсан байна.

Аймгийн нийт хүн ам 2001 онд 97234 байсан бол жил дараалан буурч 2005 оны эцэст 91092 болж буурсан нь төрөлт багасч, шилжих хөдөлгөөн их байгаатай холбоотой байна.

Шилжих хөдөлгөөн нь хүн амын төвлөрсөн зам дагуух сумдад илүү байгаагийн дээр багаас сум, сумаас аймаг, аймгийн төвөөс Улаанбаатар хот, Эрдэнэт хот, Дархан шилжих нь их байна. 2004 онд шилжин ирэгсэд 75 байхад шилжин явагсад 3856 болж 2000 оныхоос 45.2 хувь өсчээ.

Энэ нь зах зээлээс хол, ажлын байргүй, томоохон үйлдвэр хөгжөөгүйтэй холбоотой гэж үзэж байна. Аймгийн хүний хөгжлийн индекс 0.635 болж улсын дунджаас 8.0 хувиар доогуур байна. Иймээс аймгийн хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх, шилжих хөдөлгөөн, ядуурал ажилгүйдлийг бууруулах, улмаар хүний хөгжлийн түвшинг дээшлүүлэх шаардлагатай байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Аймгийн хүн амын өсөлтийг дэмжиж, хүний хөгжлийн түвшинг дээшлүүлнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> - Аймаг, сумын түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлэх арга механизмыг бий болгож нэвтрүүлэх. - Хөдөөгийн хүн амын сурч боловсрох, орлого олох, бизнес эрхлэх, мэдээлэл, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх талаар хот суурин газрын иргэдээс доогуур байгаа ялгааг арилгах бодлогыг хэрэгжүүлэх. - Ажлын байрны хангамжийг сайжруулах, хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулах. - Айл өрхөөр угийн бичиг хөтлүүлэх, овог сэргээх ажлыг эрчимжүүлэх. - Мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжилд хүн амыг бэлтгэх ажлыг зохион байгуулах. - Аймаг, сум, багийн түвшинд өрх айл, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх замаар хүний хөгжлийг тууштай дээшлүүлэх. - Боловсрол, соёл, урлаг, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх. - Хүний амьдралын нийгэм, эдийн засаг, орчин ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх. - Хүүхэд залуучуудыг үйлдвэрлэлийн сургалтад хамруулах, гадаад орнуудад явуулж сургах.

Гарах үр дүн		Аймгийн хүний хөгжлийн индекс 0.016 функтаар нэмэгдэж, хүн амын дундаж наслалт 66-д хүрнэ.
2. Хүн ажиллаж, амьдрах нийгэм, эдийн засаг, орчин ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар хүний хөгжлийг хурдасгана.	2011-2015	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлэх арга механизмыг төгөлдөржүүлж улам боловсронгуй болгох. - Ажлын байрны хангамжийг сайжруулж, хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг бууруулах замаар хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах. - Төрөлтийг дэмжих, өрхийн хүүхдийн тоо, насны ялгааг харгалзан тэтгэлэг олгох арга хэмжээ авах. - Угийн бичиг хөтлүүлэх ажлыг бүрэн хэрэгжүүлэх. - Малчдыг зайны сургалтанд хамруулах. - Хүн ажиллаж амьдрах нийгэм, эдийн засаг, орчин ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх.
Гарах үр дүн		Хүн амын тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдэнэ.

2.2. Хүн амын ядуурал, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар:

2.2.2. Хүн амын ядуурал, ажилгүйдлийг бууруулах талаар:

Үндэслэл

2005 оны байдлаар аймгийн нийт хүн ам, өрхийн дотор өрх толгойлсон эмэгтэйчүүд 2620, өндөр настай ганц бие өрх 1215 болж 2004 оныхоос 10.4-22.7 хувь өссөн, АБТДО-той өрхийн тоо 13235 болсон нь нийт өрхийн 54.5 хувийг эзэлж үүнээс нэн ядуу өрх 5400 гаруй байна.

Хөдөлмөр эрхлээгүй 6.5 мянган хүн, хөдөлмөрийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1638 байгаа нь 2004 оноос 117 хүнээр өсч ажилгүйчүүдийн 52.9 хувийг эмэгтэйчүүд, 0.7 хувийг мэргэжилгүй 8.9 хувийг тусгай дунд боловсролтой хүмүүс эзэлж байна.

Ажилгүйдэл их байгаа нь ядуурал нэмэгдэх, сахилга дэг журам алдагдах, гэмт хэрэг өсөх нэг үндэс болж байна. 2005 онд гэмт хэргийн тоо 2004 оныхоос 10.9 хувь өсч гэмт хэрэгт холбогдогчид 464 болж 3.8 хувь нэмэгджээ.

Ажилгүйдэл, ядуурал нь нийгмийн олон сөрөг үр дагаварыг үүсгэж байна.

Амьжиргааны түвшин доогуур байгаа нь өрхийн хүн ам өдөр тутмын хоол хүнс болон бусад хэрэгцээгээ хангаж чадахгүй, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг бүрэн хүргэж чадахгүй байна.

Иргэдийн бизнес эрхлэж бие даан амьдрах мэдлэг дадлага, туршлага дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс бүрэн салаагүй байгаа зэргээс хамаарч ажилгүйдэл, ядуурал буурахгүй харин ч өсөх хандлагатай байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Ажилгүйдэл, ядуурлаас гарах оновчтой арга зам боловсруулж хэрэгжүүлнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> - Өрх, хүн амын амьжиргааны түвшин, түүний орлого, зарлага, ажилгүйдэл, ядуурал үүс байгаа талаар нарийвчилсан судалгаа явуулж дүгнэлт гаргах. - ӨАЧДҮХ, ХЯБХ-ийн хөрөнгийг жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд бодлогоор зохицуулах. - Хөдөөд өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх. - Иргэдэд эдийн засгийн боловсрол олгох сургалт семинарыг зохион байгуулах. - Албан бус хөдөлмөр эрхлэгчид малчид, тариаланчдыг нийгмийн даатгалд хамруулах. - Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөж, жижиг, оврын техник, тоног төхөөрөмжийг лизингээр олгох үйлчилгээг өргөтгөх. - Фермерийн аж ахуй, хоршоо, малчдын бүлэг байгуулах санаачлагыг дэмжих. - Төмс, хүнсний ногооны эрэлт хэрэгцээг дотоод үйлдвэрлэлээр хангах ажлыг зохион байгуулж, ажлын байр нэмэгдүүлэх.
Гарах үр дүн		АБДТДО-той өрхийн тоог 2005 оныхоос 40 хувиар бууруулна.
2. Ажилгүйдэл ядуурлыг бууруулж арилгах механизмыг хэрэгжүүлж, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	2011-1015	<ul style="list-style-type: none"> - Аймгийн эдийн засгийн өсөлтийг хангах, ядуучуудыг ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлэх. - Төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа үр нөлөөг аймаг, сумдад идэвхжүүлж уялдаа холбоог сайжруулах. - Хөдөлмөр, эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байраар хангах, нийгмийн халамжийн үйлчилгээг жинхэнэ эзэнд нь хүргэх, тавих хяналтыг сайжруулах. - Албан бус салбарт ажиллагсдын сэтгэлгээг өөрчлөх, тэдэнд даатгал, татварын бодлогын ач холбогдлыг ойлгуулж, орлогоо үнэн зөв мэдээлдэг тогтолцоог бүрдүүлэх. - Ажилгүйдэл ядуурлыг бууруулахад чиглэсэн дотоод, гадаадын зээл тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлж айл өрхийн орлогыг өсгөх. - Хөдөлмөр эрхлээгүй хүн, ядуу айл өрх, иргэнгүй сум, баг болох хөдөлгөөнийг өрнүүлж дүгнэх.
Гарах үр дүн		АБТДО-той иргэдийн тоог 2010 оныхоос 2.0 дахин бууруулна. Ажилгүйдлийн түвшин 3.0 хувь болно.

2.4. Хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх талаар:

Үндэслэл

Аймгийн хүн амын боловсролын түвшинг авч үзэхэд хүн амын 36.2 хувийг бага боловсролтой, 35.6 хувийг бүрэн бус дунд, 18.7 хувийг бүрэн дунд, 6.3 хувийг тусгай мэргэжлийн дунд болон бүрэн бус дээд, 3.2 хувийг дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж 3.8 хувь нь бичиг үсэг үл мэддэг байна.

Энэ нь бүрэн бус дунд, бага, боловсролгүй хүмүүсийн эзлэх хувийн жин улсын дунджаас 2.5-3.5 функтаар өндөр, харин дээд, ТМД, ТМ-н болон бүрэн дунд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин улсын дунджаас 0.5-4.5 функтаар доогуур байгааг харуулж байгаа нь аймгийн хүн амын боловсролын түвшинг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Аймгийн ЕБС-д 21325, хүүхдийн цэцэрлэгт 2485, багшийн коллежид 978, МСҮТ-д 425, хувийн их дээд сургуулиудад 476 сурагч, оюутанууд 2005-2006 оны хичээлийн жилд суралцаж байна. 2005 онд сургууль завсардсан 61 хүүхэд, цэцэрлэгийн насны хүүхдийн хамралт 56.3 хувьтай, сургуулийн дотуур байранд суух шаардлагатай хүүхдийн 68.2 хувь нь хамрагдаж, 816 багш, сурган хүмүүжүүлэгч ажиллаж байгаагийн 97.2 хувь нь мэргэжлийн, 48.8 хувь нь мэргэжлийн зэрэгтэй байна.

Боловсролын салбарт багшлах боловсон хүчний хүрэлцээ хөдөөд дутмаг, мэргэжил олгох, мэргэжилтэй ажилчин, боловсон хүчнийг бэлтгэх, хангамж, сургалтын чанар хангалтгүй байна. Цэцэрлэгийн насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдах хүрээг өргөжүүлэх, боловсрол, хүүхдийн цэцэрлэгийн материаллаг баазыг өргөжүүлэх, техник хэрэгслээр хангах шаардлага эрэлт хэрэгцээнээс хоцорч байна.

Соёлын төвүүдийн материаллаг баазыг бэхжүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлагатай байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Боловсролын бүх шатны байгууллагуудын үйл ажиллагааны шинэчлэлийг гүнзгийрүүлж, сургалтын чанарыг сайжруулж, материаллаг баазыг нь бэхжүүлнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none">- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу ЕБС-ийн бүтэц, байршлыг оновчтой болгох.- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон дотуур байрны нөхцөлийг сайжруулж, хичээлийн байр, танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх.- Энэ чиглэлээр барилгыг шинээр барих, өргөтгөх, засварлаж материаллаг баазыг сайжруулах.- ЕБС-ийг 11 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлж, 12 жилийн тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангах.- ЕБС-ийг компьютержүүлж техник хэрэгслээр хангах, интернетэд холбох, зайны сургалт бий болгох, англи хэлний гүнзгийрүүлсэн эрчимтэй сургалт явуулах.- Гадаад хэлний сургалтын болон сурлагын чанарыг сайжруулж, англи, орос, хятад хэлний сургалтыг нэмэгдүүлэх.

		<ul style="list-style-type: none"> - Цэцэрлэг хотод иж бүрэн үйлчилгээтэй номын өргөө байгуулах. - Сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн эзэмшүүлэх, ажил мэргэжлийн чадвар, дадалтай болгох, хүн амын ерөнхий боловсролын түвшинг ахиулах сургалтуудыг зохион байгуулж, бичиг үсэг үл мэдэх явдлыг бууруулах. - Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийг аймаг, сумын төвд байгуулан ажиллуулахад дэмжлэг үзүүлэх. - Боловсролын удирдах ажилтан, багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалтын менежментийг боловсронгуй болгох. - Сум бүрт сургуулийн өмнөх боловсролын ээлжийн бүлэг, зуны сургалт явуулах, гэр цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх. - Их дээд сургууль, коллежийн оюутан, ахлах ангийн сурагчдад зориулсан “Соёл мэдээллийн төв” байгуулж үйлчилгээг тогтмолжуулах. - МСҮТ-ийн сургалтын агуулгыг шинэчилж, сургалтын чанарыг дээшлүүлэх, төгсөгчдийг ажлын байртай болгоход дэмжлэг үзүүлдэг тогтолцоо бий болгох. - Эмзэг бүлгийн өрхийн сургуулийн насны оюуны хөгжил сул, тахир дутуу хүүхдүүдэд сурч хүмүүжих нөхцөл бололцоогоор хангахад дэмжлэг үзүүлэх. - Сургууль, хүүхдийн цэцэрлэгийг туслах аж ахуйтай болгож, туслах аж ахуйгаа хөгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх.
Гарах үр дүн		Суурь боловсролд хамран сургалт нэмэгдэн боловсролын материаллаг бааз бэхжинэ.
2.Соёл урлагын салбарын үйл ажиллагааг зах зээлийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	2006-2010	<ul style="list-style-type: none"> - Соёл урлагын байгууллагуудын үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн зохион байгуулж, менежментийг сайжруулах. - Уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлэн соёл урлагын хүртээмжийг нэмэгдүүлэх. - Аймагт номын өргөө байгуулах. - Сумдын соёлын төвүүдийн байрны хангамж, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авах. - Музей үзмэр, түүх соёлын дурсгалт зүйлсийн бүртгэлийг мэдээллийн тоон сүлжээнд хамруулах. - “Ардын уламжлалт урлаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх. - “Цогчин дуган”-ыг сэргээн засварлах.

Гарах үр дүн	Соёл урлагын үйл ажиллагаа үйлчилгээ тогтмолжиж, материаллаг бааз бэхжинэ.
3. Боловсролыг тогтолцоо сургалтын хэв шинжийг ОУ-ын нийтлэг жишигт хүргэж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.	<p>2011-2015</p> <ul style="list-style-type: none"> - Суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх. - Сурагчдад бизнесийн мэдлэг олгож, хэрэглээний зохистой дадал чадварыг эзэмшүүлэх. - Мэргэжлийн сургалттай ахлах сургуулийг бий болгож, бодлогын хэмжээнд дэмжиж ажиллах. - ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн бүтэц, хэв шинжийг ОУ-ын жишигт хүргэх ажлыг зохион байгуулах. - Хүүхдэд ээлтэй сургууль, цэцэрлэгийн орчин бүрдүүлэх. - Боловсролын тогтолцоонд хувийн хэвшлийн эзлэх байр суурь, хамрах хүрээг нэмэгдүүлж, тэдэнд дэмжлэг үзүүлэх. - Албан бус боловсрол олгох, зайны сургалтын сүлжээ бий болгох. - Сургууль завсардалтыг зогсоож, бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах. - Хүүхдийн авъяасыг нээн илэрүүлж хөгжүүлэх арга хэмжээг өргөтгөх. - Багшийн коллежийг түшиглүүлэн хөрвөх чадвартай багш бэлтгэх. - ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материал, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, үйл ажиллагааны хүрээг өргөтгөж үйлчилгээ, сургалтын чанарыг дээшлүүлж цэцэрлэгийн хамралтыг 90.0 хувь, сургуулийн дотуур байрт хамралтыг 95.0 хувьд тус тус хүргэх. - ЕБС, Цэцэрлэгийн цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэж, нар, салхины эрчим хүчээр хангахад дэмжлэг үзүүлэх. - Мэдээлэл, харилцааны технологийг сургалтанд өргөн нэвтрүүлэх.
Гарах үр дүн	Боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинж ОУ-ын жишигт нийцэж үйлчилгээ, сургалтын чанар 2010 оноос 5.0 функтаар дээшилнэ.
4. Соёл, урлагын байгууллагын бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.	<p>2011-2015</p> <ul style="list-style-type: none"> - Соёл, урлагын өвийг хадгалах хамгаалах, авъяастан, урчууд, уран бүтээлчдийг шинээр илэрүүлж сурталчлах тусгай хөтөлбөр боловсруулж хөгжүүлэх. - Соёлын үйлчилгээг хөдөөгийн хүн амд хүргэх ажлыг сумдын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн зохион байгуулах.

		- Аймгийн ХДТеатр, сумын соёлын төвүүдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх санал санаачлагыг дэмжих. - Соёл, урлагын салбарт үзүүлэх дэмжлэг, зохицуулалтыг оновчтой болгож, зах зээлийн харилцаанд шилжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх.
Гарах үр дүн		Соёлын өвийг хамгаалах, хадгалах, сурталчилах үйл ажиллагаа, урлагын үйлчилгээний чанар сайжирна.

2.5. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар:

Үндэслэл

Аймгийн хүн амд нийгмийн эрүүл мэндийн газрын харъяа нэгдсэн эмнэлэг, 19 сумын эмнэлэг, өрхийн эмнэлэг, 99 багийн эмч, БГХӨТГазар, улс болон хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сан, эмийн худалдаа үйлчилгээний...цэгүүд эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.

Эдгээр байгууллагуудад 125 их эмч, 764 эмнэлгийн дунд мэргэжилтэн, 617 ор ажиллаж байгаа нь 10000 хүнд 13 их эмч, 47 эмнэлгийн дунд мэргэжилтэн, 68 эмнэлгийн ор ногдож байна. Нөгөө талаар нэг их эмчид ногдох хүний тоогоор Хангайн бүсийн дунджаас 17.9 хувь, нэг сувилагчид ногдох хүний тоогоор 10.1 хувиар тус тус илүү байна.

Гэвч аймгийн эрүүл мэндийн салбарт нарийн мэргэжлийн их эмч, мэргэжилтэн дутагдалтай, боловсон хүчний хангалт, мэргэжлийн ур чадварын түвшин өнөөгийн шаардлагаас хоцрох, төсвийн болон материаллаг баазын хүрэлцээнээс хамаарч эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, орчин үеийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түргэн тусламжийн машин, эмийн болон лабораторын урвалж бодисын хангамж дутагдалтай, хувийн болон хот суурин газрын ариун цэвэр, хүн амын хүнсний бүтээгдэхүүний чанар, усан хангамж нь эрүүл ахуйн наад захын шаардлага хангахгүй байгаагаас өвчлөл ихэсч улмаар эндэгдэлд хүргэхэд нөлөөлж байна.

Аймгийн хүн амын дунд цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл, амьсгалын зам, хоол боловсруулах, вируст гепатит, бэлгийн замын болон улаан хоолой, элэгний хорт хавдарын өвчлөл олон тохиолдож, 2005 оныг 2004 онтой харьцуулахад эхийн эндэгдэл 50.0 хувь, нялхсын эндэгдэл 21.4 хувь өссөн байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
1. Аймгийн эрүүл мэндийн бодлогыг тодорхойлж, хүн амын эрүүл мэндийн	2006-2010	- Эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагын бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох. - Сумдын эхчүүдийн амрах байруудыг

<p>боловсролыг сайжруулж аймаг, сумын эмнэлгийг бэхжүүлнэ.</p>		<p>өргөтгөж, засварлах, шинээр барьж тохижуулах.</p> <ul style="list-style-type: none"> - Өвчлөл, жирэмсний хүндрэлийг эрт илэрүүлэх оношлуурын сүүлийн үеийн арга, технологийг аймаг, сумын түвшинд нэвтрүүлж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эх, хүүхдийн зохистой хооллолтын талаар сургалт явуулах, хоол тэжээлийн хангалт, бүтцийн чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх. - Аймаг, сумдын эмнэлгийн чадавхийг сайжруулах, эмч боловсон хүчнийг сургах, мэргэшлийг дээшлүүлэх. - Сумдын болон өрхийн эмнэлгийн материаллаг бааз, оношлогоо, эмчилгээний багаж, аппарат, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах. - Шивэртийн ахмадын амралтыг нөхөн сэргээх, эмчилгээ, рашаан сувилал, байгаль-эмчилгээний төв болгох. - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын стандартыг хангуулах - Бэлгийн замын өвчин, ДОХ-оос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж эрчимжүүлэх. - Эмнэлгийн байруудыг засварлах, шинээр барих ажлыг улам эрчимжүүлэх. - Хот суурин газрын ариун цэвэр, хүнсний бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, ундны усны хатуулаг, эрдэсжилтийг зөөлрүүлэх. - Нийтийн биеийн тамирын хөдөлгөөнийг хүн амыг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, урт наслах нөхцөл бүрдүүлэхээр бүх нийтийн хөдөлгөөн болгож өрнүүлэх. - Ахмад настан, тахир дутуу иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөтгөх.
<p>Гарах үр дүн</p>		<p>Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар дээшилнэ.</p>

<p>2. Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх нөхцөлийг бүрдүүлэх замаар хүн амын өвчин эндэгдлийг бууруулна.</p>	<ul style="list-style-type: none"> - Эх нялхсын эрүүл мэндэд онцгой анхаарч, эндэгдлийг бууруулах арга хэмжээ авах. - Халдварт өвчинтэй тэмцэх явдлыг хүчтэй болгож, халдварт өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакцины нөөцийг зохих түвшинд бүрдүүлэх. - Зүрх судасны өвчин, хорт хавдар, ослоос шалтгаалсан нас баралтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. - Хүн ам, хүүхдийн дунд зонхилон тохиолдож байгаа өвчний оношлогоо эмчилгээг сайжруулан хүүхдийн өвчлөлтийг багасгаж, нялхсын болон хүүхдийн эндэгдлийг 2005 оноос 50 хүртэл хувиар бууруулах /1000 хүүхдэд/ - Хүн амын вакцинжуулалтын түвшинг аймагт 100.0 хувь, бүсийн төв сумдад 95.0 хувьд хүргэх.
<p>Гарах үр дүн</p>	<p>Өвчин эмгэгийг оношлох, эмчлэх нөхцөл бүрдэж улмаар хүн амын өвчлөл, эндэгдэл буурна.</p>
<p>3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.</p>	<p>2011-2015</p> <ul style="list-style-type: none"> - 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийг 50.0 хувиар бууруулах арга хэмжээ авах. - Эрүүл аж төрөх ёсны мэдлэг олгох сургалтыг хэвшүүлэх. - Хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж өргөжүүлэх. - Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах - Хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэх тогтолцоог улам боловсронгуй болгох. - Эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчний чадварыг нэмэгдүүлж, эмчлэн анагаах чадамжийг улсын дундаж түвшинд хүргэх. - Бүх сумдад биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төв байгуулах. - Эмч, эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай сум, багт мэргэжилтэн сууршин ажиллах эдийн засгийн хөшүүрэг бий болгож хэрэгжүүлэх.
<p>Гарах үр дүн</p>	<p>Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, амьдрах, ажиллах, суралцах, эрүүл ахуйн таатай орчин бүрдэнэ.</p>

3. Төрийн бодлого, гадаад харилцаа

Үндэслэл

2005 оны байдлаар 3525 төрийн албан хаагч ажиллаж байгаагийн 404 нь төрийн захиргааны, 211 нь төрийн тусгай, 2910 нь төрийн үйлчилгээний албан хаагчид байна. Төрийн албан хаагчдын 615 буюу 17.4 хувь нь бакалаврын болон түүнээс дээш зэрэг цолтой, 1746 буюу 49.5 хувь нь дипломын боловсролтой байгаа нь нийт төрийн албан хаагчдын 67.1 хувийг эзэлж байна.

Гэвч төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлэх үйлчилгээ, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар шаардлагаас хоцрох, тэдний үүрэг хариуцлага, аймаг, сумдын Тамгын Газруудын материаллаг бааз, ажлын байрны хүрэлцээ, ажиллах нөхцөл хангалтгүй, орчин үеийн техник, тоног хэрэгслээр хангагдаагүй байна.

Эдийн засгийн гадаад харилцаа хөгжөөгүй байна. Иймд төрийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, ажлын байрны хүрэлцээ, техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулах, өнөө үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чадварлаг мэргэжилтэнтэй төрийн албан хаагчдаар бэхжүүлж, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй, ил тод, олон нийтийн оролцоо санал хүсэлтэд нийцүүлэх, гадаад харилцааг аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үр ашигтайгаар өргөжүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна.

Тэргүүлэх зорилт	Үе шат /оноор/	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл
<p>1. Хүний хөгжил, төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулах замаар тэдний үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, ажиллах нөхцөл баталгааг сайжруулна.</p>	<p>2006-2015</p>	<ul style="list-style-type: none"> - Аймгийн хүний нөөц, боловсон хүчний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх. - Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг салбаруудын ерөнхий менежерүүдийн чадавхийг хөгжүүлэх зорилттой уялдуулан шийдвэрлэж, мэргэжилтэй ажилчны тоог нэмэгдүүлэх. - “Төрийн албан хаагчийн сургалт”, “Ажиллах нөхцөл”, “Нийгмийн баталгаа” хөтөлбөрүүдийг төрийн байгууллагуудад гаргаж мөрдөн хэрэгжүүлэх. - Төрийн албаны стандартыг хэлбэрэлтгүй сахин мөрдөж, төрийн албан хаагчдын хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх. - Төрийн албан хаагчид хос мэргэжил эзэмжиж, ажлын байранд хөрвөж ажиллах чадварыг эзэмшсэн байх. - “Цахим засаглал” хөтөлбөрийг мөрдөж хэрэгжүүлэх. - Төрийн байгууллагын албан тушаалын ажлын байрыг мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлэх. -Төрийн байгууллага бүрийн үйл ажиллагааны дотоод журмыг шинэчилэн мөрдөж дэг журам сахилга, хариуцлагыг өндөржүүлэх. - Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хувийн жинг 30.0 хувьд хүргэх.

		<ul style="list-style-type: none"> - Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох ажлыг өргөжүүлэх. - Сумдын Тамгын Газрын барилгыг засварлах, өргөтгөх, шинээр барих, тохижуулах ажлыг зохион байгуулах. - Төрийн албаны бүх ажлын байрыг хүний нөөцийн бүртгэлтэй болгох. - Төрийн албан хаагчдыг гадаад оронд суралцуулах, туршлага судлах ажлыг өргөжүүлэх.
Гарах үр дүн		Төрийн албан хаагчдын хариуцлагын тогтолцоо бүрдэн, ажиллах нөхцөл баталгаа сайжирна.
2. Төрийн албан хаагчдыг техник хэрэгслээр хангаж, олон нийттэй харилцах харилцааны менежментийг боловсронгуй болгож, иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бүрдүүлнэ.	2006-2015	<ul style="list-style-type: none"> -Нутгийн захиргааны болон төрийн байгууллагуудын ажилтан нарыг орчин үеийн ширээ, сандал, техник хэрэгслээр хангаж, компьютержүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах. -Төрийн байгууллагуудын төсвийг бодит хэрэгцээнд нийцүүлж нэмэгдүүлэх. -Тамгын Газруудын парк шинэчлэлийг ээлж дараалалтай хийх. -Төрийн байгууллагуудыг чийрэгжүүлэлтийн танхимтай болгож ажиллагааг нь тогтмолжуулах. - Төрийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж үр нөлөөг дээшлүүлэх -Ард иргэдээс санал, асуулга авах, төрийн үйлчилгээнд сэтгэл ханамжийн үнэлгээ авдаг журмыг байгууллага бүрт тогтоож хэрэгжүүлэх. -Ажил үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлж, давхардлыг арилгаж, төрийн байгууллагуудыг цомхон, чадварлаг мэргэжсэн бүтцээр ажиллуулж, үйл ажиллагааг нь хөнгөн шуурхай хүртээмжтэй, ил тод болгох үйл явцад чанарын өөрчлөлт гаргах. - Төрийн байгууллагын үйл ажиллагаанд нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх.
Гарах үр дүн		Төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай, ил тод байдал хангагдана.

<p>3. Хүний болон байгалийн болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, арилгах ажилд бүх түвшинд тогтвортой үйл ажиллагаа явуулна.</p>	<p>2006-2015</p>	<ul style="list-style-type: none"> - Гамшиг, аюулаас урьдчилан сэргийлэх хамгаалахтай холбогдсон сургалт, сурталчилгааг өргөжүүлэх. - Гамшгаас хамгаалах албаны мэргэжлийн боловсон хүчнийг гадаад, дотоодод сургаж бэлтгэх. - Аймгийн улс болон орон нутгийн гамшиг ослоос хамгаалах нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг өнөөгийн шаардлагад нийцүүлж өөрчлөн түүний хуваарилалт, зарцуулалтыг оновчтой болгох. - Гамшиг, аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах. - Гал унтраах болон аврах ажлын техник хэрэгсэл, тоног зэвсэглэмжийг шинэчлэх, сайжруулах.
<p>Гарах үр дүн</p>		<p>Бэлэн байдалд байх нөхцөл бүрдэнэ.</p>
<p>4. Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын чанарыг сайжруулж иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p>2006-2015</p>	<ul style="list-style-type: none"> - Цагдаагийн албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах. - Цагдаагийн албан хаагчдад хүний эрхийн боловсрол эзэмшүүлэх. - Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг ил тод болгож авилгатай тэмцэх. - Эрүүлжүүлэх, баривчлах байрын нөхцөлийг сайжруулж эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх. - Гамшгаас хамгаалах болон Цагдаагийн байгууллагын материаллаг бааз машин техник, тоног төхөөрөмж, холбооны хэрэгслээр бүрэн хангах ажлыг зохион байгуулах. - Малын хулгай, чонотой тэмцэх тусгай хөтөлбөрийн заалтуудыг бүрэн хэрэгжүүлэх.
<p>Гарах үр дүн</p>		<p>Гэмт хэргийн гаралт 2006 оныхоос 20.0 хувь буурч, иргэдийн амьдрах нөхцөл дээшлэнэ.</p>
<p>5. Гадаад харилцааг аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд ашигтайгаар өргөжүүлэн хөгжүүлнэ.</p>	<p>2006-2015</p>	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлж, өргөжүүлэх. -.....улс, оронтой боловсрол, эрүүл мэнд, соёлын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх. - Гадаад харилцаа, хамтын ажиллагаатай улс орнуудад мэргэжилтнүүд явуулж зах зээл, туршлага судлуулах, оюутан сургах, ажилчин, ажилтан бэлтгэх. - Аймгийн “Брэнд” бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа гаргаж сурталчилах. - Гадаадын байгууллага, иргэдтэй

		түншлэлийн холбоо тогтоох ажлыг өргөтгөж, гадаадад ажиллахыг дэмжих. - Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэх.
	Гарах үр дүн	Гадаадтай харилцах эдийн засаг, нийгмийн харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжинө.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл:

Аймгийн 2006-2015 оны хөгжлийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, эдийн засаг, нийгмийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, ард иргэдийн оролцоог нэмэгдүүлж хөхүүлэн дэмжих зэргээр хөгжилд хүргэх оновчтой арга хэрэгслийг ашиглах нь тулгамдсан зорилт болно.

4.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл:

- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль болон аймгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймаг, сум, байгууллагын ажлын хэсэг томилон ажиллуулж үр дүнг тооцож ажиллах.

- Сум, аж ахуйн нэгж, байгууллага тус бүрийн 2006-2015 оны хөгжлийн хөтөлбөр боловсруулж 5 жил тутам үр дүнг дүгнэж тайлагнах.

- Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг гадаад дотоодын төрөл бүрийн хөтөлбөр төсөлтэй уялдуулж жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгаж хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх.

- Хөтөлбөрт тусгасан тэргүүлэх зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймаг, сумдын Засаг дарга нар мөрийн хөтөлбөртөө нарийвчилан тусгаж хэрэгжүүлэх.

- Байгаль хамгаалах, цөлжилттэй тэмцэх зардлыг улс, орон нутгийн төсөв болон бусад төсөл, хөтөлбөрүүдийн эх үүсвэрт тусгах.

- Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, газар ус бохирдуулагчдад хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож мөрдөх.

- Байгалийн баялаг, ашигт малтмалын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх удирдлага зохион байгуулалт, эрх зүй, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авч хуулийг хэрэгжүүлэх.

4.2. Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга хэрэгсэл:

- Аймаг, сумдын бүсийн төвүүдийг бусад бүстэй холбосон дэд бүтцийн үндсэн сүлжээг бүрдүүлэхэд улсын хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх.

- Орон нутгийн өмч, санхүү, төсөв, зээлийн эрх мэдлийг өргөтгөх.
- Орон нутгийн төсвийг эдийн засгийн бодлоготой нягт уялдуулж, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тоо чанар, үр дүнгээр санхүүжилт олгодог журамд бүрэн шилжих.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа, аж ахуйн нэгж, байгууллагын хүн ам, аж ахуйн нэгжийн орлогын, нэмэгдсэн өртөг, онцгой албан татвар, ашигт малтмал /алт г.м/ ашигласны нөөцийн төлбөр зэрэг төсвийн орлогуудыг орон нутагтаа төвлөрүүлж, зарцуулах.
- Бүсийн хөгжлийг дэмжих сан бий болгож, жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх ажлын байр шинээр бий болгох, техник технологийн шинэчлэл хийсэнд дэмжлэг үзүүлж, урамшуулал олгох механизм бий болгох.
- Эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлж, бүх салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх.
- Мал, газар тариалангийн үйлдвэрлэлийг даатгалын ба эрсдэлээс хамгаалах тогтолцоонд бүрэн шилжүүлэх.
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн тусламжийг зохицуулах, оновчтой зарцуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах.

4.3. Олон нийтийн оролцоо:

- Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын зохицуулалтын эрх мэдэл, үүргийг өргөтгөж, аймгийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.
- Эдийн засаг, нийгэм, байгаль орчны хөндлөнгийн хяналтыг олон нийтийн хяналтад шилжүүлэх.
- Өрхийн аж ахуй эрхлэхэд туслах сайн дурын байгууллага бий болгох.
- Гэмт хэрэг, малын хулгайтай тэмцэхэд иргэдийн оролцоог идэвжүүлэх, мэдээллийг бүрэн нууцлах.
- Айл өрх бүрээр угийн бичиг хөтлүүлэх ажлыг эрчимжүүлэх.
- Иргэдэд экологийн боловсрол хүмүүжил олгох сургалт явуулах, байгаль экологийг хамтран хамгаалах, ашиглах, үржүүлэх асуудлыг хариуцуулах.
- Газар, усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах асуудлыг зохицуулж олон нийтийн зөвлөл ажиллуулах, ойжуулах, ойн хортон шавьж устгах арга хэмжээнд олон нийтийг татан оролцуулах.
- Байгаль, усны эх үүсвэрийг хамгаалах уламжлалт арга, зан үйлийг сэргээж хөгжүүлэх.

5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт, явц үр дүнд үнэлгээ өгч, хүндрэл бэрхшээл, тасалдлыг арилгаж, хөтөлбөр хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх явдал юм.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээг жил бүр хийж, 2010, 2015 онуудад дараах шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж дүгнэнэ.

Хяналт шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт, хэмжих нэгж	Хүлээгдэж буй үр дүн /хувиар/	
	2010	2015
Эдийн засгийн хөгжил		
• Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ний жилийн дундаж өсөлт	10.0	7.0
• Аж үйлдвэрийн салбарын ДНБ-ний жилийн дундаж өсөлт	15.0	10.0
• Аймгийн ДНБ-д боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувийн жин	5.0	10.0
• Аймгийн ДНБ-д уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин	2.0	4.0
• Аймгийн үйлчилгээний салбарын ДНБ-ний жилийн дундаж өсөлт	9.0	7.0
• ХАА-н үйлдвэрлэлийн ДНБ-ний жилийн дундаж өсөлт	8.0	7.0
• Аймгийн ДНБ-д газар тариалангийн үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин	5.0	7.0
• Аймгийн ДНБ-д МАА-н бүтээгдэхүүний эзлэх хувийн жин	75.0	80.0
• Хөрөнгө оруулалтын өсөлт	2.5 дах	3.0 дах
Нийгмийн хөгжил		
• Хүн амын жилийн дундаж өсөлт	1.1	1.5
• Хүн амын дундаж наслалт	66	69
• Эхийн эндэгдлийн бууралт	33.3	50.0
• Нялхсын эндэгдлийн бууралт	20	17
• Ажилгүйдлийн түвшин	3.7	2.5
• Гэмт хэргийн бууралт	10.0	20.0
• АБТДО өрхийн эзлэх хувь	25.1	12.5
• Суурь боловсролын хамран сургалтын өсөлт	95.0	100.0
• Хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт	70.0	90.0
• Дотуур байрын хангамж	80.0	95.0
• Хүн амын орон сууцны хангамжийн түвшин	40.0	60.0
Байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалал		
• Түлшний хэрэглээнд шахмал болон шингэрүүлсэн түлш, хийн эзлэх хувь	5.0	10.0
• Нийт газар нутагт тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	15.0	25.0
• Аймгийн агаарын бохирдолын хэмжээний түвшин	0.003-0.015 хэтрэхгүй	
• Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зардлын өсөлт	2.5 дах	3.0 дах